

**СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ УЛИРЛЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ,  
ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1. Энэхүү журам нь хүн амыг стратегийн хүнсээр жигд, тогтвортой хангах, үнийн зохиомол хөөрөгдлөөс сэргийлэх зорилгоор малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усны улирлын нөөцийг бүрдүүлэх, хадгалах, зарцуулах харилцааг зохицуулахад оршино.

2. Хүнсний тухай хуулийн 6.3, 6.5-д заасны дагуу Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**Хоёр. Улирлын нөөц бүрдүүлэх үйл ажиллагаа**

2.1. Стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлэх, хадгалахад шаардагдах хөрөнгийг тухайн жилийн орон нутгийн төсвөөс гаргана.

2.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нар нутаг дэвсгэрийнхээ хүн амын тоо, өсөлттэй уялдуулан стратегийн хүнсний хэрэгцээ, эрэлт, нийлүүлэлтийг судлан, дараа жилийн улирлын нөөц бүрдүүлэх хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоож, саналыг хүнсний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 5 дугаар сарын 1-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.3. Хүнсний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага энэхүү журмын 2.2-т заасан саналыг нэгтгэн дүгнэж, Монгол Улсын стратегийн хүнсний улирлын нөөцийн нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.

2.4. Засгийн газар нь Монгол Улсын хүн амын стратегийн хүнсний улирлын нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг тогтоож, шаардагдах хөрөнгийг тухайн жилийн орон нутгийн төсөвт суулгах шийдвэрийг 2 дугаар улиралд багтаан гаргана.

2.5. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Засгийн газраас тогтоосон нэр төрөл, тоо хэмжээнд багтаан энэхүү журмын 2.6-д заасан ажлын хэсгийн саналыг үндэслэн орон нутгийн стратегийн хүнсний улирлын нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, чанарын шаардлага болон бүрдүүлэх, хадгалах, зарцуулах, эргүүлэн төвлөрүүлэх хугацаа, хуваарийг аж ахуйн нэгж бүрээр гаргаж захирамжаар баталж, мөрдөж ажиллана.

2.6. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах, хүнсний нөөцийн чанар, аюулгүй байдал, хадгалалт, зарцуулалт, эргүүлэн төвлөрүүлэлтэд хяналт тавих Ажлын хэсгийг байгуулна.

2.7. Ажлын хэсэг нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.7.1. Тухайн орон нутагт энэхүү журмын 2.5-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүд сонгон шалгаруулалтад оролцох урилгыг нөөц бүрдүүлж эхлэх хугацаанаас 45-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж, албан хүсэлт, үнийн саналыг хүлээн авна.

2.7.2. Санал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийг энэхүү журмын 3.2-т, хүнсний нөөцийн нэр төрөл, чанар, аюулгүй байдал, тоо хэмжээ, үнийн саналыг энэхүү журмын 3.1-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

2.7.3. Хүнсний улирлын нөөцийн бараа бүтээгдэхүүнийг түгээх, худалдан борлуулах цэг салбар, сүлжээ дэлгүүрүүдийг энэхүү журмын 3.3-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу шалгаруулна.

### **Гурав. Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхэд тавигдах шаардлага:**

#### **3.1. Нөөцийн бараа бүтээгдэхүүнд:**

3.1.1. Тухайн бүтээгдэхүүн нь стандартын шаардлагыг бүрэн хангасан, хадгалалтын хугацаанд бүтээгдэхүүний хугацаа дуусахааргүй байх;

3.1.2. Тухайн бараа бүтээгдэхүүн нь гарал үүслийн болон бусад чанар, аюулгүй байдлын шинжилгээнд хамрагдаж баталгаажуулалт хийгдсэн байх;

3.1.3. Үйлдвэрийн аргаар бэлтгэж боловсруулсан;

3.1.4. Савласан нөөцийн бараа бүтээгдэхүүн нь стандартын шаардлагын дагуу хаяглаж, шошиглосон байна.

#### **3.2. Нөөцийн бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах аж ахуйн нэгжүүдэд:**

3.2.1. Дотоодын үйлдвэрлэгчийн хувьд сүүлийн 2-оос доошгүй жил хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, хуулийн этгээд байх.

3.2.2. Үйлдвэрлэл нь MNS CAS RCP 1 “Хүнсний эрүүл ахуйн зарчим” стандартын шаардлагыг хангасан байна.

3.2.3. Нөөцийн бараа бүтээгдэхүүн хадгалах хөргөлттэй агуулах нь орчны температур, харьцангуй чийглэгийг хянах боломжтой зориулалтын багаж, төхөөрөмжөөр тоноглогдож, баталгаажсан байна.

3.2.4. Үйлдвэрийн байр, агуулах, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав, баглаа боодлын материал, тээврийн хэрэгслийн угаалга, ариутгал, халдваргүйтгэлийг дотоод журмын дагуу гүйцэтгэж, бүртгэл хөтөлсөн байна.

3.2.5. Нөөцийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах, хуваарийн дагуу түгээх, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэргэжилтэй боловсон хүчний нөөцтэй байна.

3.2.6. Нөөцийн бараа бүтээгдэхүүнийг ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан, хөргүүр бүхий зориулалтын тээврийн хэрэгслээр, технологийн зааврын дагуу хурааж тээвэрлэнэ.

#### **3.3. Хүнсний нөөцийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах түгээх цэг сүлжээ дэлгүүрт:**

3.3.1. Хүнсний бараа бүтээгдэхүүний худалдааны чиглэлээр сүүлийн 2-оос доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, хуулийн этгээд байх;

3.3.2. Худалдааны байр нь хүнсний бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байх

3.3.3. Хүнсний бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн хадгалах зориулалтын агуулах, зориулалтын тээврийн хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

3.3.4. Хүнсний бараа бүтээгдэхүүнийг худалдаалах зориулалтын хөргүүртэй лангуу, тавиур, хөргөгчөөр бүрэн хангагдсан байх.

3.3.5. Хэмжих хэрэгслийг бүрэн баталгаажуулсан байх.

### **Дөрөв. Нөөцийн менежментийн гэрээ байгуулах**

4.1. Сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжүүд нөөцийн бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, хадгалах, түгээн борлуулах менежментийн гэрээг байгуулна. Гэрээнд дараах үндсэн нөхцлийг тусгасан байна.

- Бэлтгэх нөөцийн бараа бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ;
- Нөөцийн бараа бүтээгдэхүүнд тавигдах чанар, аюулгүй байдлын шаардлага;
- Нөөцийн бараа бүтээгдэхүүн нийлүүлэх үнэ, барааг нийлүүлэх хуваарь;
- Нөөцийн бараа бүтээгдэхүүн хадгалах агуулахын байршил, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл;
- Хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын нөхцөл шаардлага, хугацаа;
- Бүрдүүлэлт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын үеийн эрсдэлийн хариуцлага;
- Дотоодын болон хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх арга зам;
- Хөрөнгийн буцаан төвлөрүүлэх арга зам гэх мэт.

### **Тав. Нөөцийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах, түгээн борлуулах шатанд тавих хяналт**

5.1. Хүнсний нөөцийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх явцад тухайн үйлдвэрлэгч дотоодын хяналтыг тавьж ажиллана.

5.2. Мэргэжлийн хяналтын байцаагч нар засаг захиргаа нутаг дэвсгэрийнхээ харъяаллын дагуу хүнсний нөөцийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хөндлөнгийн хяналт тавина.

5.3. Дүүрэг хороодын Засаг дарга, холбогдох төрийн бус байгууллагууд тухайн нутаг дэвсгэрт байрлаж байгаа худалдааны цэг салбаруудад хүнсний нөөцийн бараа бүтээгдэхүүнийг батлагдсан хуваарь, хэмжээ, үнээр хэрэглэгчид түгээж байгаа эсэх, борлуулах цэг салбарын лангуу тавиур, агуулах, тээврийн хэрэгсэл нь технологи, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана. Энэхүү хяналтыг хэрэгжүүлсэн тухай тайлан болон авах арга хэмжээний талаарх санаалыг тухай бүр Ажлын хэсэгт хүргүүлнэ.

5.4. Ажлын хэсэг нь хүнсний бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх, хадгалах, түгээн борлуулах гэрээний биелэлт, нөөцийн сангийн зарцуулалтыг сар бүр шалгаж санал дүгнэлтийг аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулна.

5.5. Хүнсний нөөц бүрдүүлэх, хадгалах, борлуулахаар шалгарсан аж ахуйн нэгж нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлаж, хохиролыг төрүүлж, дараагийн шалгаруулалтад оролцуулах боломжгүй.